



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 661

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалт, Ховд аймгийн Засаг даргын 2022 оны А/72 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн орон нутгийн төсвийн санхүүжилтээр бий болсон, 20,000,000.00 (хорин сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Гадаадын иргэн, харьяатын газрын харьяа Баруун бүс дэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006945
34-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
66 дугаар тогтоолын хавсралт



ХОВД АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН БАРУУН БҮС ДЭХ ГАЗАРТ
БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Автомашин, тоёота приус XW20, 33-12 ХОЕ	1	20,000,000.00	20,000,000.00
	Нийт дүн			20,000,000.00 (хорин сая)